



ДУНДГОВЬ АЙМАГ
БАЯНЖАРГАЛАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын _____ өдөр

Дугаар А/59

Аргатай


Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.21, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.10, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ний өдрийн 61 дүгээр тушаалын 2.1.5, 2.1.6, аймгийн Засаг дарга сумын засаг даргатай хамтран ажиллах гэрээний 5.23, Засаг даргын зөвлөлийн 01 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гамшгаас хамгаалах иж бүрэн сургалтын бэлтгэл ажлыг хангах сумын онцгой комисс, гамшгаас хамгаалах ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийн бэлтгэл, бэлэн байдлыг хангуулах, ажиллах нөхцөл, боломжоор хангах, дэмжлэг үзүүлэх арга хэмжээний зардлыг 3300.000 (Гурван сая гурван зуун мянган) төгрөгөөр баталсугай.

2. Нутаг дэвсгэрийн онцлогт нийцүүлэн гамшгаас хамгаалах ерөнхий зориулалттай мэргэжлийн анги, сайн дурын хэсгийн бие бүрэлдэхүүнийг гамшгийн үед үүрэг гүйцэтгэх дадлага, сургалтад идэвхтэй оролцуулж иж бүрэн сургуулийг үр дүнтэй зохион байгуулахыг мэргэжлийн ангийн дарга (Р.Отгонбаатар)-т үүрэг болгосугай.

3. Гамшгаас хамгаалах ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийг ажиллах нөхцөл боломжоор хангахад шаардлагатай 3300.000 (Гурван сая гурван зуун мянга)-н төгрөгийг сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Р.Отгонбаатар), нягтлан бодогч (А.Цогзолмаа)-д тус тус зөвшөөрсүгэй.

ДАРГА  О.УУГАНБААТАР